



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4
1. Жендэрийн үндсэн ойлголт	4
2. Жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт	7
3. Аргачлалд туссан жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын үзүүлэлтүүд	12
4. Жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтыг улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд нэвтрүүлэх талаар	23

УДИРТГАЛ


Аливаа улс орон эдийн засаг болон нийгмийн дэд бүтцийг үүн дотроо дэд бүтцийн барилга байгууламжуудыг бий болгох, боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээг хүргэхийн тулд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төслүүдийг хэрэгжүүлдэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл бүр иргэд, олон нийтэд зориулсан, олон нийтийн ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг бүрэн хангадаг байх гэсэн суурь зарчмуудыг хангах учиртай.

Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй хүний хэрэгцээ, шаардлага, өөрчлөгдөж буй технологийн шинэчлэл, инновацийн хөгжлийн энэ цаг үед төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, төсвийн зорилтууд ч мөн эдгээр өөрчлөлт, шинэчлэлийг мэдэрч, тусгах хэрэгтэй байна.

Төсвийн хөрөнгө оруулалт нь урт хугацааны шинж чанартай тул санхүүжилт хийгдсэн барилга байгууламжууд, дэд бүтэц нь олон жилийн аяыг дааж, олон олон хүний хэрэгцээг хангадаг, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж чадах чанартай баригдсан байх ёстой.

Ингэхийн тулд хаана, юуг, хэнд зориулж, хэдий хэмжээний зардлаар, ямар төслөөр хэрэгжүүлэх вэ? гэдгийг шийдэх нь хамгийн чухал үе шат бөгөөд үүнд талуудын оролцоог хангаж, саналыг тусган, хяналтыг хэрэгжүүлэх нь онцгой ач холбогдолтой. Төлөвлөлтийн үе шат хэр сайн хийгдэнэ, тэр хэрээр хэрэгжилт, ашиглалт нь сайн байх нөхцөл бүрдэх юм.

Энэхүү гарын авлага нь жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд нэвтрүүлэхэд чиглэсэн. Энэ үүднээсээ төсвийн санхүүжилтаар хэрэгжих аливаа төсөл нь хэрхэн эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ялгаатай хэрэгцээг мэдэрч, хангах, тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлтийг эрэлхийлсэн, иргэдийн оролцоог хангасан байдлаар төлөвлөгдөх вэ? эдгээрийг ямар үзүүлэлтүүдээр үнэлж хөрөнгө оруулалтын төслийн эрэмбэлэлтэд харгалзаж үзэх вэ? гэдэг талаар Та бүхэнд товч ойлголт өгч, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үйл ажиллагааны журам, аргачлалд оруулах шалгуур үзүүлэлтүүдийг санал болгож байна.



“Хүйс” нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн насан туршид нь үл өөрчлөгдөх биологийн ялгааг илэрхийлдэг.

“Жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эмэгтэй, эрэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;

“Жендэрийн эрх тэгш байдал” гэж эмэгтэй, эрэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг;

“Жендэрийн хэвшмэл үзэл” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эмэгтэй, эрэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг;

“Жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эмэгтэй, эрэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

“Жендэрийн мэдрэмжтэй байдал” гэж эмэгтэй, эрэгтэйчүүдийн олон талт ялгаатай байдлыг харгалзан, тэдгээрийн ялгаатай хэрэгцээг тооцоолон, эрх тэгш байдлыг тогтоох шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх хандлага;

“Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт үйл ажиллагаанд тусгах (gender mainstreaming)” гэж аливаа хууль тогтоомж, бодлого хөтөлбөр болон хөгжлийн бүхий л санаачилгад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, ялгаатай хэрэгцээг харгалзан тооцох замаар жендэрийн эрх тэгш байдлыг тогтооход чиглэсэн үйл явц, стратеги юм.

“Жендэрийн мэдрэмжтэй хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэж аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны орц, хэрэгжилтийг түүнд оролцох эмэгтэй, эрэгтэйчүүдийн оролцоотойгоор тухайн бодлогын үр дүн, үр нөлөө (эерэг, сөрөг) тэдэнд ялгаатай байгаа эсэх талаар шалгуур үзүүлэлт тогтоон, холбогдох нарийвчилсан мэдээлэл цуглуулах, хяналт үнэлгээ хийх үйл явцыг хэлнэ.

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” (ЖМТ) гэдэг нь төсвийн бүхий л үйл явцад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах үйл явц юм. ЖМТ нь санхүүгийн нөөцийн илүү оновчтой, үр өгөөжтэй хуваарилах, зарцуулах, нийгэм, орон нутаг, хамт олны дотор байгаа жендэрийн аливаа асуудлыг шийдэх боломжийг бодитой болгодог шинжилгээний чухал хэрэгсэл юм.

Жендэрийн хяналтын хуудас нь аливаа бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-үнэлгээний шатанд жендэрийн үзэл баримтлалыг үйл ажиллагаанд нэгтгэх үйл явцад хэрэглэх жендэрийн нөхцөл байдлыг шалгах асуулт, эсвэл үзүүлэлтийн жагсаалт юм.

Оролцоонд суурилсан жендэрийн аудит гэдэг нь жендэрийн үзэл баримтлалыг үйл ажиллагааны түвшинд нэвтрүүлэхэд хэрэглэх хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал билээ. Энэ нь жендэрийн үзэл баримтлалыг бодлого, хөтөлбөр, бүтэц зохион байгуулалтдаа бодит үр дүнтэйгээр тусган хэрэгжүүлэх, энэ явцад байгууллагын хүрээнд суралцах үйл явцыг дэмжих,

түүнийг байгууллага, салбар нэгж, ажилтны түвшинд үнэлэхэд чиглэдэг.

Оролцоонд суурилах нь жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн чухал зарчим болно. Дүн шинжилгээ хийх, бодлогын зорилго, зорилтыг тодорхойлох, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, хянаж үнэлэх бүх шатанд холбогдох талуудын төдийгүй зорилтот бүлгийн бодит оролцоог хангах ёстой.

“Хүйсээр ангилсан тоон мэдээлэл” гэж эмэгтэй, эрэгтэйгээр ангилагдсан мэдээллийг хэлнэ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг¹ хэлнэ.

Тусгай арга хэмжээ гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүний тэгш бус байдлыг арилгах, тэгш байдлыг тогтооход чиглэсэн зориудын арга хэмжээ. Ийм арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үздэггүй. Тэгш боломж, тэгш байдал тогтоох зорилго биелэгдмэгц тусгай арга хэмжээг зогсооно.

Ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрт байдлыг хангах гэдэг нь эмэгтэй, эрэгтэй ажилтны гэр бүлдээ хүлээх үүрэг, хариуцлага, эмэгтэйчүүдийг албан тушаал дэвшихэд саад болж буй хүчин зүйлс, эсвэл бага цалин хөлстэй ажилд ороход хүргэж буй шалтгаан, эрэгтэйчүүдийн хувьд гэр бүлдээ оруулах хувь нэмэр, чадавхыг хязгаарлах, эрүүл мэндтэй холбоотой эрсдэлийг бий болгож буй хүчин зүйлсийг илрүүлэн бодлого төлөвлөлтөд харгалзан тусгах явдал. Энэхүү ажил-ар гэрийн амьдралын төлөвлөлт, тэнцвэрт байдлыг харгалзсан бодлого нь жендэрийн эрх тэгш байдлын суурь шаардлагын нэг юм.

¹ Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 4.1.1-р зүйл



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг боловсруулах, хөрөнгө оруулалтыг төлөвлөх үйл ажиллагаа нь дараах хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг.

2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд: Үүрэг хүлээгчдийн бүрэн эрхийг нэг бүрчлэн тодорхойлсон. Үүнд:

Улсын Их Хурал нь төрийн бодлого, хууль тогтоомжийг хүний эрхэд суурилсан жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байхаар тодорхойлох; эмэгтэй, эрэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

Засгийн газар нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, **жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх**, хөтөлбөр, тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг батлуулах; жендэрийн бодлого, үйл ажиллагааны үр дүнгийн талаар Улсын Их Хуралд тайлагнах.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь тухайн салбарын хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах; төслийг үнэлгээний тайлан, зөвлөмжийн хамт Засгийн газарт өргөн мэдүүлэх; хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх үүрэгтэй хэмээн заасан.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2017-2021/ (Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоол)-т:

Хөтөлбөрийн зорилго нь Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг хангах, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангахад оршино.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ТУЛД ДАРААХ ЗОРИЛТУУД ДЭВШҮҮЛСЭН:

- Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх;
- Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх;
- Эмэгтэй, эрэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох; хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагад баримтлах жендэрийн стратеги (2016-2024)-ийн тэргүүлэх зорилт 3-ыг дараах байдлаар тодорхойлсон. “Сангийн сайдын болон зарим төсөв ерөнхийлөн захирагчийн төсвийн үйл явцыг үе шаттайгаар жендэрийн мэдрэмжтэй болгоно.”

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮДЭД:

1. Орон нутгийн, салбарын, үндэсний хөгжлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, хөгжлийн болон төсвийн бодлого, тэдгээрийн уялдаа холбоонд жендэрийн шинжилгээ хийх ур чадварыг хөгжүүлэх,
2. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн эрх зүй, бодлогын орчныг хөгжүүлэх,
3. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга хэрэгслийг боловсруулах
4. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэхэд шаардагдах судалгааг хийж, арга хэрэгслүүдийг туршин нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах,
5. Хамтын ажиллагааны хүрээнд жендэрийн үндэсний бодлого төлөвлөлтийн санхүүжилтийг дэмжих.

Энэхүү стратеги нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд нэвтрүүлэх (Gender mainstreaming) аргачлалд тулгуурлах бөгөөд хувь хүмүүсийн жендэрийн асуудлаарх мэдлэг чадварыг хөгжүүлэн, энэ чиглэлээр ажиллах боломжийг нээж, бодлого төлөвлөлт, арга зүйгээр дэмжих нь уг стратегийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болно.

Эдгээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тулгуурлан жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг ч жендэрийн хувьд мэдрэмжтэй, эрх тэгш байдлыг хангасан байлгахад анхаарал хандуулах хэрэгтэй юм.

Жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт нь улс орнуудад дараах 3 үе шатаар хэрэгждэг. Үүнд:

1-р үе шатанд хөрөнгө оруулалт нь нийгэм, хамт олонд тулгарч буй жендэрийн асуудал, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг шийдэхэд тус нэмэр болж байгаа эсэхийг шинжлэн дүгнэх ажил хийгдэнэ. Энэ шатанд төсвийн хөрөнгө оруулалтын эцсийн хэрэглэгчдийн талаарх мэдээллийг нэгтгэж дүгнэнэ.

2-р үе шатанд өмнөх шинжилгээний үр дүнд тулгуурлан төсвийн хөрөнгө оруулалтын үр шимийг сайжруулах ажлуудыг төлөвлөнө. Хөрөнгө оруулалтад тавигдах хяналт, эрх зүй бодлогын орчныг сайжруулах, хүйсээр ангилсан мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, чадавх бэхжүүлэх, нөлөөлөх ажлуудын хэрэгцээг тодорхойлно.

3-р үе шатанд жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтыг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын төслийн үйл явцад нэгтгэж жендэрийн дүн шинжилгээний үзүүлэлтийг боловсруулж тасралтгүй, тогтмол хийгдэх ажил болгон албажуулна. Түншлэгч байгууллага, төрийн бус байгууллагууд, иргэдийн бүлгүүдийг жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын асуудлаар чадавхжуулах сургалт хийж тэдний оролцоог хангах нь энэ шатанд зайлшгүй хийгдэх ажлуудын нэг билээ.

Жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт гэдэг нь төсвийн хөрөнгө оруулалтын бүхий л үйл явцад жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах үйл явц юм. Жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулалтын санхүүгийн нөөцийг илүү оновчтой, үр өгөөжтэй хуваарилах, зарцуулах, нийгэм, орон нутаг, хамт олны дотор байгаа жендэрийн аливаа асуудлыг шийдэх боломжийг бодитой болгоход чухал ач холбогдолтой.

Төсвийн хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч болохын зэрэгцээ төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөө нь олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжил, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар дэвшүүлсэн Засгийн газрын зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой. Эмэгтэй, эрэгтэйчүүдийн бүлгүүд нь хөрөнгө оруулалтын төслөөс ялгаатай байдлаар үр шим хүртдэг тул хөрөнгө оруулалтын томоохон төслийн үнэлгээ, сонгох үйл явцад жендэрийн асуудлыг тусгах нь чухал ач холбогдолтой. Тухайлбал, олон нийтэд зориулсан

шинэ орон зайг бий болгох зорилгоор спортын заал барихдаа зориулалтын тусдаа хувцас солих өрөө болон ариун цэврийн өрөөгүй, гаднах гудамж нь гэрэлтүүлэггүй, нийтийн тээвэр хүртээмжгүй тохиолдолд эмэгтэйчүүд, охидын хувьд аюулгүй байдал нь хангагдаж чадахгүй, түүнчлэн эмэгтэй, эрэгтэй олон янзын бүлгүүд тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуус, ахмад настны ялгаатай хэрэгцээг хангах төслийн анхны зорилт хэрэгжих боломжгүйд хүрнэ.

Иймд улсын болон орон нутгийн төсвөөр баригдаж буй барилга байгууламжид ялгаатай хэрэгцээтэй, тусгай анхаарал шаардаж буй бүлгүүдийн онцлог хэрэгцээг хангахад чиглэсэн тусгай өрөө, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хувцас солих тусдаа өрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон нөхөн үржихүйн онцлогоос хамаарч охид, эмэгтэйчүүдэд зориулсан ариун цэврийн өрөө хангалттай байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай орц, гарц, тусгай анхаарал шаардаж буй эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинет байгуулах, нийгмийн тусгай хэрэгцээт бүлгүүдэд сургууль, цэцэрлэгийн барилгын байршил ойр эсэх зэргийг тусгайлан анхаарч жендэрийн дүн шинжилгээнд үндэслэн барилга байгууламжийн зургийг гаргасан, төлөвлөсөн, төсөвлөсөн эсэхийг төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээ хийх бүхий л шатанд анхаарах нь зүйтэй.



АРГАЧЛАЛД ТУССАН ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Журмын 3.1.7. төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт дэх жендэрийн мэдрэмжийн үзүүлэлтийг тодорхойлох, тайлан гаргах

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журмын 3.1.7-д заасны дагуу Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь “төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт дэх жендэрийн мэдрэмжийн үзүүлэлтийг тодорхойлох, тайлан гаргах” чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Жендэрийн үзэл баримтлалыг төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх бүх үе шатанд тусгаж үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж төсөвлөх шаардлагатай. Үүний тулд төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэлд жендэрийн шалгуур үзүүлэлтийг ашиглах, тухайн хөрөнгө оруулалтын зорилтот бүлэг, үр шимийг хүртэгчдийг хүйсээр ялган тодорхойлох шаардлагатай. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд жендэрийн мэдрэмжтэй үзүүлэлтийг боловсруулахдаа тоон болон чанарын дараах мэдээллийг харгалзан үзнэ. Үүнд:

- Эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай байдлыг хэмжих;
- Нийгмийн янз бүрийн гишүүдийн үүрэг, хариуцлага, нөөцийг хүртэх үр шимийг хэмжих;
- Жендэрийн тэгш байдлыг хангах зорилтын явцыг хэмжих;
- Тоон мэдээллийг хүйс, нас, бусад хэмжээсээр ангилах;
- Тоон мэдээлэлд жендэрийн дүн шинжилгээ хийх;
- Бодлого, хөтөлбөр, төслийг төлөвлөхөөс эхлээд хэрэгжүүлэх, хянах, үнэлэх хүртэлх бүхий л үе шатанд жендэрийн асуудлыг анхаарч тусгах;
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх мэдлийн харилцаанд гарсан өөрчлөлтийн нөлөөг харуулах²

Жендэрийн статистикийн мэдээллийн эх сурвалж:

- www.1212.mn
- <https://ncge.gov.mn/>
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011 он
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сангуудын талаарх мэдээлэл <https://libraryresources.unog.ch/c.php?g=462654&p=3163155>

Холбогдох тушаалууд:

- Жендэрийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, 2019 оны 11-р сарын 19 -ний өдрийн Үндэсний статистикийн газрын даргын А 173-р тушаал
- Жендэрийн статистикийн үзүүлэлт, 2019 оны 11-р сарын 19-ний өдрийн Үндэсний статистикийн газрын даргын А 173-р тушаалын нэгдүгээр хавсралт

² <https://policy-practice.oxfam.org/resources/quick-guide-to-gender-sensitive-indicators-312420/>

Журмын 3.3.7. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө олон нийтийн саналыг авсан байх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж, эсвэл мэргэжилтэн нь “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журмын” хүрээнд хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхдөө олон нийтийн саналыг авсан байх шаардлагатай. Олон нийтийн саналыг авах ажлыг ... хэлбэрээр ... сард багтаан зохион байгуулна.

Аргачлал 3-ын ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ-ны 8 дахь шалгуур үзүүлэлт болох “жендэрийн мэдрэмжтэй төсвийн хөрөнгө оруулалт эсэх”

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлалын хүрээнд Төслийн үнэлгээг хийх явцад тухайн төсөл нь жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт эсэхийг дараах 4 үзүүлэлтээр үнэлнэ.

1. Төслийг төлөвлөхдөө олон нийтийн саналыг авч тусгасан эсэх (5 оноо)

Ашиглаж болох эх сурвалж:

- https://www.irgen-tur.mn/sites/default/files/attachments/Niislel_tusuv_OK.pdf
- https://www.irgene-tur.mn/sites/default/files/documents/Irgenii_oroltsoo_buhii_huuliud_2016.pdf

Төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээний үе шатны аливаа өөрчлөлт нь жендэрийн хувьд ямар үр нөлөө үзүүлэх вэ? гэдгийг төсвийн үйл явцад оролцогчид бодолцохоос гадна иргэний нийгмийн байгууллага, иргэдийн зүгээс уг үйл ажиллагаанд мониторинг хийх нь үр дүнтэй байдаг. Тухайлбал, улс орнууд төрийн үйлчилгээний зардлыг бууруулахын тулд цэцэрлэг, яслийн барилга барихад зарцуулах төсвийг танах нь элбэг. Энэ тохиолдолд эмэгтэйчүүдийн ар гэрийн ажлын ачаалал нэмэгдэж, хөдөлмөр эрхлэхэд бэрхшээл учруулдаг. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцоо буурснаар тухайн улс орны эдийн засаг болон өрхийн төсөвт сөрөг нөлөөтэй. Иймд аливаа хөрөнгө оруулалтын төслийн нөлөөлөлд шууд болон

шууд бусаар өртөх эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саналыг төслийн бүхий л шатанд цаг алдалгүй авах нь жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын чухал хэсэг юм. Тиймээс хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангасан байдлаар жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан эсэхийг анхаарах нь зүйтэй. Оролцоог хангасан эсэхийг үнэлэхдээ дараах баримт бичгүүдээр баталгаажуулж авна. Үүнд:

- Төслийн бүхий л шатанд төслийн талаар олон нийттэй хийсэн уулзалтын протокол;
- Төслийн танилцуулга, хэлэлцүүлэгт оролцогчдийн нас, хүйс, байршлаар ангилсан мэдээлэл;
- Зураглал, дүрсжүүлэлт, фото болон бусад хэлбэрийн баримт нотолгоо, баримтжуулалт.

Төслийн боловсруулалт дахь олон нийтийн оролцоог үнэлэхдээ дараах шалгах хуудсыг бөглөн оноо өгнө. Үүнд:

Шалгах хуудас

№	Шалгуур	Тийм	Үгүй
1.	Төслийн танилцуулгын шатанд олон нийттэй хийсэн уулзалтанд оролцогчдын мэдээлэл /нас, хүйс, нас, байршил/ бий эсэх	1	0
2.	Оролцоог хангах жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө бий эсэх	1	0
3.	Хэлэлцүүлэгт нэг хүйсийн төлөөлөл 40-өөс доошгүй оролцох гэсэн зарчмыг хангасан эсэх	1	0
4.	Хэлэлцүүлэг оролцогчдын мэдээлэл, өгсөн саналд дүн шинжилгээ хийж, төсөлд тусгасан эсэх (Дүн шинжилгээний тайлан бий эсэх)	1	0
5.	Тухайн төслийн үр шим хүртэгч эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээг харгалзан үзсэн тусгай арга хэмжээ, залруулга бий эсэх	1	0

2. Төслийг хэрэгжүүлснээр бий болох барилга байгууламжийг ашиглахад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээ бүрэн хангагдах боломжтой эсэх (4 оноо)

Тухайн хөрөнгө оруулалтын төсөлд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг тусгасан, орон нутгийн онцлог, хүн амын бүтэц амьжиргааны түвшин, өрх толгойлсон байдал, өрх бүрт ахмад настан, жирэмсэн эмэгтэй, 0-5 насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, нэн ядуу, түр оршин суугч, хүчирхийлэлтэй, туслалцаа дэмжлэг шаардлагатай өрх эсэх зэрэг мэдээллийг багтаасан нийгмийн зураглалыг гаргаж, жендэрийн дүн шинжилгээ хийнэ. Энэхүү *дүн шинжилгээний үр дүн, тайланг* хөрөнгө оруулалтын төслийн үнэлгээний гол чухал үнэлгээний шалгуур болгоно.

Жендэрийн дүн шинжилгээнд жишээлбэл, жендэрийн тэгш бус байдлыг харгалзан түүний зорилго, үйл ажиллагаа болон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээ, илүүтэйд үзэж буй зүйлийг тусгасан эсэх; хэдэн эмэгтэй, эрэгтэй хүн үйл ажиллагааны тухайлбал, үзүүлэх үйлчилгээ, бий болгосон дэд бүтцийн ашиг тусыг хэрхэн хүртсэн; бусад үйлчилгээнд эмэгтэй, эрэгтэй хүмүүс ялгаатай хамрагдсан уу; хэрэв тийм бол шалтгаан нь юу вэ; үйлчилгээг хүртэхэд ямар саад тотгор учирсан байж болох; эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тусгай үйлчилгээ санал болгосон эсэх; үзүүлсэн үйлчилгээний талаарх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн сэтгэл ханамж ямар түвшинд байсан; эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ажил эрхлэлтэд хэрхэн нөлөөлөх; тухайн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны төслийг зорилтот бүлгийн хүн амын тоотой харьцуулахад хүрэлцээтэй байна уу гэх мэт голлох асуултуудыг багтаана. Эдгээр дүн шинжилгээнд үндэслэн *жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ЖУАТ)-г* боловсруулна. ЖУАТ гэдэг нь төсвийн хөрөнгө оруулалтын төслийн бүх оролцогч талуудын жендэрийн талаар хийх үйл ажиллагааг цаг хугацаа, үе шат, хяналт-шинжилгээ, мониторинг багтаасан цогц арга хэмжээ бөгөөд жендэрийн дүн шинжилгээний үр дүн, дүгнэлт, зөвлөмжид үндэслэнэ. Энэхүү ЖУАТ нь хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх бас нэгэн шалгуур болно.

Төслийн төлөвлөлтөд эмэгтэй, эрэгтэй ялгаатай хэрэгцээг тусгасан эсэхийг үнэлэхдээ дараах шалгах хуудсыг бөглөн оноо өгнө. Үүнд:

Шалгах хуудас

№	Шалгуур	Тийм	Үгүй
1.	Хөрөнгө оруулалтын төслөөс ашиг хүртэх тухайн орон нутгийн, хорооны эсвэл багийн иргэдийн хүйс, насаар ангилсан тоо баримт байгаа эсэх	1	0
2.	Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг тодорхойлох жендэрийн анализ хийгдсэн эсэх ³	1	0
3.	Жендэрийн анализид үндэслэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан эсэх	1	0
4.	Төслийн ашиг шим хүртэгчдийн нэг хүйсийн төлөөлөл 40-өөс доошгүй байгаа эсэх	1	0

3. Төслийн зураг төсөвт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлт тусгагдсан эсэх (3 оноо)

Аливаа төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх ёстой. Үүнийг олон улсын конвенцүүд болон манай улсын холбогдох хуулиудад тодорхой тусгасан байдаг. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцийн 9-р зүйлд хүртээмжийн талаар тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг хүртээмжтэй орчин гэнэ хэмээн тодорхойлсон.

Хүртээмжтэй байх явдалд учруулах саад, тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг дараах газарт авна. Тухайлбал, барилга байшин, зам, тээвэр болон сургууль, орон сууцны байр, эмнэлгийн газар, ажлын байр зэрэг бүх төрлийн доторх болон гаднах байгууламж зэрэг болно.

³ Эмэгтэй, эрэгтэй хүний ялгаатай хэрэгцээг тусгасан тухайлбал, сургуулийн барилгад эмэгтэй, эрэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан ариун цэврийн өрөө тус тусдаа давхар бүрт бий эсэх (Эмэгтэй сурагчдын тухайд ариун цэврийн өрөө давхар бүрт 2 байх)

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны стратегийг Ази болон Номхон Далайн бүс нутагт орших хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан 1993-2002 он ба 2003-2012 онуудад дарааллан хэрэгжүүлсэн 10 жилийн 2 хөтөлбөрийн туршлага болон 2006 онд Ерөнхий Ассамблейн батласан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид суурилж боловсруулсан. Уг стратегийн гол зарчмуудын нэг нь хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан, жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн бодлого болон хөтөлбөр, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэх боломжийг олгох технологийн дэвшилтийг дэлхий дахины загвартай хослуулах боломжийг олгох явдал юм.

Монгол Улсын хувьд 2016 онд батлагдсан **“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”**-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчимд “хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх; ялгаварлан гадуурхалтын талаар тодорхой зааж өгсөн бөгөөд тус хуулийн 6, 8, 9-р зүйлд **дэд бүтэц**, орон сууц, **олон нийтийн барилга байгууламжид** саадгүй хүрэх, **сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байвал** ялгаварлан гадуурхалт хэмээн тодорхойлж, **барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох** хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн баримт бичгийг боловсруулах, хяналт шалгалт хийх холбогдох зардлыг улсын төсөвт тусгах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах зэрэг арга хэмжээг авч, зардлыг барилга, зам, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэнэ хэмээн заасан байдаг.

Хот байгуулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бий болгох, 20.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах төлөвлөлтийг гүйцэтгэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм ба дүрэм, журамд заасныг баримтална. Түүнчлэн, 20.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтын шийдэл, зураг төсөл, инженерийн болон

нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохыг хориглоно хэмээн заажээ.

Эдгээрээс гадна Монгол Улсын Барилгын тухай хуульд дараах заалтыг тусгасан байдаг. Үүнд:

9 дүгээр зүйл. Барилга байгууламжид тавих шаардлага

9.1. Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна:

9.1.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээг хангасан;

10 дугаар зүйл. Барилгын зураг төсөлд тавих шаардлага

10.1.3-т хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах арга хэмжээг тус тус тусгасан.

Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд жендэрийн дүн шинжилгээний тайлан, зөвлөмжийг үндэслэн үнэлэхээс гадна барилга байгууламжийн зураг нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй, эрэгтэй иргэдийн ялгаатай тусгай хэрэгцээг хангасан эсэхэд хийсэн бие даасан мэргэжлийн болон жендэрийн шинжээчдийн дүгнэлт гаргуулж хавсаргана. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон янзат байдал, тухайлбал харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын доторх болон гаднах орчин дахь тэмдэглэгээ, зам, тулгуур эрхтэн, сонсголын бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээг харгалзан үзсэн барилга байгууламжийн зураг, дэд бүтцийг тусгасан төлөвлөлтөд зураглал, дүрсжүүлэлт, фото болон бусад хэлбэрийн баримт нотолгоог хавсаргана.

Төслийн төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах ажил хийгдсэн эсэхийг үнэлэхдээ дараах шалгах хуудсыг бөглөнө. Үүнд:

Шалгах хуудас

№	Шалгуур	Тийм	Үгүй
1.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон янзат байдал, тухайлбал харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын доторх болон гаднах орчин дахь тэмдэглэгээ, зам, тулгуур эрхтэн, сонсголын бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээг харгалзан үзсэн барилга байгууламжийн зураг бий эсэх	1	0
2.	Төслийн хэлэлцүүлэгт оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмэгтэй, эрэгтэй хүйсээр ангилсан тоо мэдээлэл бий эсэх (Нэг хүйсийн төлөөлөл 40-өөс доошгүй хувь хангагдсан эсэх)	1	0
3.	Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө бий эсэх	1	0

Төслийн зураг төсөвт эрчим хүчний хэмнэлтийн үзүүлэлт тусгагдсан эсэх (3 оноо)

Эрчим хүчний үр ашиг нь тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдаатай бөгөөд улс орны хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрстөрөгч багатай эдийн засгийн хөгжил рүү шилжихэд шаардагдах ач холбогдол бүхий үзүүлэлт юм. Барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ нь барилга, эрчим хүч, байгаль орчин, санхүүжилт зэрэг олон салбарын зангилаан дээр оршдог. Иймд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих асуудал чухал билээ.

Барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлснээр дараах эдийн засаг, нийгэм, байгаль орчины давуу талуудыг бий болгодог. Үүнд:

- Дотор агаарын чанар сайжирснаар эрүүл мэнд, бүтээмж, аюулгүй байдал сайжирна;
- Хүүхдүүдийн суралцах, эмчлүүлэгчдийн эмчлүүлэх орчин сайжирна;
- Дулааны хэрэглээ буурч, зардал хэмнэгдэнэ;
- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулна;
- Барилга, байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгана.

Иймд шинээр барих, эсвэл их засвар хийх төслүүдийн аль алинд эрчим хүчний хэмнэлтийн үзүүлэлтэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.

Барилгын салбар нь Монгол Улсын дулааны эрчим хүчний 56%, цахилгаан эрчим хүчний 38%-ийг хэрэглэж хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) ойролцоогоор 30%-ийг бүрдүүлдэг байна.⁴ Иймд эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, агаарын чанарыг сайжруулахад чиглэсэн тодорхой хууль, тогтоолыг УИХ, Засгийн газраас баталж, хэрэгжүүлж байна. Эдгээрээс дурьдвал:

- Монгол Улсын Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль (2015): Тус хуулиар эрчим хүчний өндөр хэрэглээтэй хэрэглэгчид (Үүрэг хүлээсэн хэрэглэгч)-ийг тодорхойлох, тэднийг эрчим хүчний аудитад хамруулах, эрчим хүчний хэрэглээг бууруулах төлөвлөгөөг боловсруулах, жил бүр тайлагнах зэрэг харилцааг зохицуулж өгсөн. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох эрчим хүчний хэрэглээний босго хэмжээг Засгийн газраас 2016 онд анх тогтоож, 2019 онд дахин шинэчилсэн. Барилга байгууламжийн хэрэглэгчид төрийн байгууллагын 3000 м², бусад байгууллагын 5000 м²-аас дээш талбай барилга байгууламжтай, 300 кВт.ц/м² жил хэрэглээтэй, эрчим хүч хэрэглэгчийн хувьд уул уурхайн компаниудын хувьд 5000 МВт.ц, бусад аж ахуйн нэгж байгууллагад 4000 МВт.ц ба түүнээс дээш цахилгаан эрчим хүч зарцуулдаг аж ахуйн нэгжийг хамруулжээ.
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2007 онд батлагдаж, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) нь сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн асуудлыг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Хууль батлагдсанаар сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, ашиглах дотоодын нөхцөлийг сайжруулах ажлыг эрчимжүүлсэн.
- Агаарын чанарын тухай хууль (2012) нь агаарын чанарын асуудлыг илүү сайн шийдвэрлэхийн тулд гарсан. Тус хуулийн зорилго нь орчны агаарыг хамгаалах, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, агаарыг бохирдуулагч бодисын ялгарлыг бууруулах, хяналт-шинжилгээ үнэлгээтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022) нь 2017 онд батлагдсан. Энэхүү хөтөлбөрт барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээний түвшинг тодорхойлох, тэдгээрийн эрчим хүчний хэрэглээг баталгаажуулах арга, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон байгууламж, пассив барилга байгууламжийн үндэсний шаардлагыг

⁴ Барилга, хот байгуулалтын яам

тодорхойлох, барилга байгууламжийн дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг дэмжих санхүүгийн хөшүүргийг бий болгох зэрэг арга хэмжээ багтсан байна.

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн барилгын эрчим хүчний бодит хэрэглээг мэдэх, ингэснээр төлбөр тооцоог дулааны тоолуураар хийх боломж бололцоог олгож Монгол Улсын хэмжээнд тоолуур суурилуулах ажлыг захирамжилсан “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай” хэмээх Засгийн газрын 144-р тогтоол 2020 онд батлагдсан.
- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 146-р тушаалаар батлагдаж, 2021 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр мөрдөгдөх БНБД 25-01-20 “Барилгын дулаан хамгаалалт”-ын норм, дүрэм нь барилгуудын дулааны эрчим хүчний хэрэглээний шаардлагыг тогтоож өгсөн. Уг барилгын норм ба дүрмийг тодорхой температур-чийглэгийн горим барих шаардлагатай шинээр барих ба шинэчлэн засварлах орон сууц, олон нийт, үйлдвэр, хөдөө аж ахуйн болон 50м² -аас их талбайтай агуулахын барилга байгууламжийн дулаан хамгаалалтыг төлөвлөхөд мөрдөнө хэмээн заасан.

Төсөл нь эрчим хүчний хэмнэлтийг анхаарсан эсэхийг үнэлэхдээ дараах шалгах хуудсыг бөглөнө. Үүнд:

Шалгах хуудас

№	Шалгуур	Тийм	Үгүй
1.	Барилгын дулаан хамгаалалтын шаардлагыг хангасан эсэх (БНБД 25-01-20 “Барилгын дулаан хамгаалалтын нормын 5.1-р заалт” ⁵)	1	0
2.	Дулааны тоолууртай эсэх	1	0
3.	Эрчим хүчний гүйцэтгэлийн гэрчилгээтэй эсэх	1	0

⁵ 5.1. Барилгын дулаан хамгаалалтын гадна гадаргуу (нийт гадна хашлага бүтээц) нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: а) хашлага бүтээцийн дулаан дамжуулалтын эсэргүүцэл нь эрчим хүч хэмнэлтийн нормчилсон утгаас багагүй байх (хэмнэлтийн шаардлага); б) барилгын дулаан дамжуулалтын хувийн үзүүлэлт нь нормчилсон утгаас ихгүй байх (ерөнхий шаардлага); в) хашлага бүтээцийн дотор гадаргуугийн температур нь зөвшөөрөгдөх хамгийн бага утгаас багагүй байх (эрүүл ахуйн шаардлага). Эдгээр 3 шаардлага бүрийг биелүүлснээр барилгын дулаан хамгаалалтын шаардлагыг хангана.



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦАХИМ СИСТЕМД НЭВТРҮҮЛЭХ ТАЛААР

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам ба аргачлалууд”-д жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бий болгох шалгуур үзүүлэлтийг оруулж өгсөн.

Жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж эхлэхийн тулд дараах алхмууд хийгдэнэ. Үүнд:

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөмжийг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэх;

Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газар журам, аргачлалд өөрчлөлт оруулах тушаалын төсөл боловсруулах, батлуулах

Тушаал батлагдсаны дараа улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/ буюу www.publicinvestment.gov.mn-д хөгжүүлэлтийг хийж, турших, нэвтрүүлэх.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд дараах байдлаар хөгжүүлэлтийг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, журамд дараах 3 үндсэн заалтыг тусгахаар боловсруулсан:

Тушаалын 1-р хавсралт буюу журамд

- СЯ-ТХОГ-ын чиг үүрэгт "төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт дэхь жендэрийн мэдрэмжийн үзүүлэлтийг тодорхойлох, тайлан гаргах"
- ТЕЗ-ын чиг үүрэгт "төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө олон нийтийн саналыг авсан байх"


Тушаалын 4-р хавсралт буюу төслийг үнэлэх, эрэмбэлэх аргачлалд

- 1-р үе шатны шалгуур үзүүлэлтэд "жендэрийн мэдрэмжтэй төсвийн хөрөнгө оруулалт эсэх" /4 үзүүлэлт бүхий/

Цахим системийн хөгжүүлэлтийг жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын талаар оруулж буй шалгуур үзүүлэлтийг аль үе шатанд, хаана нь оруулах вэ? гэдгийг дараах байдлаар зураглаж болно.

1.

ЖУРАМД ОРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ



2.

АРГАЧЛАЛД ОРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ

